



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2012 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А-18

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 23 дугаар тушаалын 2 дахь хавсралт буюу “Монголбанкны Хяналт шалгалтын газраас банкуудад явуулах газар дээрх шалгалтын нийтлэг удирдамж”-ийг хавсралтын дагуу шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан дээрх тушаалын 2 дахь хавсралт буюу “Банкинд иж бүрэн шалгалт хийх үлгэрчилсэн удирдамж”-ийг хүчингүй болгосугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Б.Лхагвасүрэн)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Л.НҮРЭВДОРЖ

БАТЛАВ.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

.....

**МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРААС
БАНКУУДАД ЯВУУЛАХ ГАЗАР ДЭЭРХ ШАЛГАЛТЫН
НИЙТЛЭГ УДИРДАМЖ**

... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Монголбанкны Хяналт шалгалтын газраас банкуудад явуулах шалгалтыг энэхүү удирдамжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

2. Шалгалтын зорилго нь банкны /цаашид банк гэх/-ны үйл ажиллагаа нь Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан заавар журмуудтай нийцэж байгаа эсэхийг газар дээр нь санхүүгийн баримтаар шалган тогтоож, банкны санхүү, төлбөрийн чадварын байдалд дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдалд хариуцлага тооцон, холбогдох арга хэмжээ авч арилгуулахад оршино.

3. Шалгалтыг шалгалт хамрах тайлант хугацааны бүрэн хэмжээний баримт материалд тулгуурлаж, энэхүү удирдамжийн хавсралт буюу “Удирдамжийн асуулгын хүснэгт”-ийг бөглөн CAMELS эрсдэлийн хүчин зүйл бүрээр дүгнэлт өгч газар дээрх шалгалтын хэлбэрээр явуулна.

4. Шалгалтын хэлбэр:

- Иж бүрэн
- Хэсэгчилсэн

5. Шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

- А) Ажлын хэсгийн ахлагч
- Б) Ажлын хэсгийн гишүүд

6. Банк нь шаардлагатай тайлан мэдээ, санхүүгийн баримт, материалыг ажлын хэсэгт шаардсан хугацаанд нь саадгүй гаргаж өгөх, swift сүлжээ болон бүртгэлийн бусад холбогдох программ хангамжид нэвтрэн шалгалт хийх өрөө, ажлын орчин, нөхцөл бололцоогоор бүрэн хангана.

7. Ажлын хэсгийн ахлагч нь шалгалтыг тогтоосон хугацаанд үр ашигтай хийж гүйцэтгэхэд ажлын хэсгийг зохион байгуулж ажиллахын зэрэгцээ шалгалтын явц, дүнгийн талаар болон шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шалгалтын удирдамжинд өөрчлөлт оруулах талаар саналаа Монголбанкны удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

8. Дотоод хяналтын газраас нягтлан бодох бүртгэлийг шалгасан байдал, авсан арга хэмжээ, үр дүнг шалгана.

9. Монголбанкинд сар тутам ирүүлдэг тайлан мэдээнүүдийг үнэн зөв гаргаж ирүүлж байсан эсэхийг газар дээр нь шалгаж тогтооно.

II. ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХҮРЭЭ

Нэг. Активын чанар

- 1.1 Активын /цэвэршүүлсэн/ бүтэц,
- 1.2 Касс үнэ бүхий зүйлийн хадгалалт, хамгаалалтын талаар үнэлэлт, дүгнэлт өгөх,
- 1.3 Кассын үйл ажиллагааны талаар гарсан заавар, журмын хэрэгжилт,
- 1.4 Монголбанкинд бэлэн мөнгө тушаасан байдал, түүнээс зөрчил, дутагдал гарч байсан эсэх,
- 1.5 Мөнгөн хөрөнгө, богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц, өөрчлөлт,
- 1.6 Шалгалтын акт материалыг баталгаажуулах зорилгоор шаардлагатай касс, мемориалын баримтыг шалгах,
- 1.7 Шаардлагатай гэвэл касс байгаа бэлэн мөнгөний үлдэгдлийг тоолж, кассын дэвтэр, тайлан тэнцэлтэй тулгаж шалгах,
- 1.8 Банк хооронд байршуулсан хадгаламж, харилцах дансны үлдэгдлийн үндсэн баримт, холбогдох гэрээнүүдийг шалгах,
- 1.9 Банкны худалдан авсан болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны дүн нь Банкны тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх,
- 1.10 Зээлийн бодлого, түүний хэрэгжилт, зээл олгох эрх хэмжээг тогтоосон байдалд үнэлэлт өгөх,
- 1.11 Зээлийн бүтэц /зээлийн зориулалт, төрөл, төвлөрөл, зээлийн хугацааны шинжилгээ хийх/-д үнэлэлт өгөх,
- 1.12 Нийт зээлийн багцын ... хувийг шалгах, ямар зориулалтаар олгосон зээл чанаргүй болох эрсдэл ихтэй байгааг тодорхойлох,
- 1.13 Шалгалт хамарсан хугацаанд олгосон, төлөгдсөн зээл,
- 1.14 Чанаргүй зээлийн өсөлт бууралт, түүний шалтгааныг тодорхойлж дүгнэлт өгөх,
- 1.15 Анхны нөхцөл өөрчлөгдсөн зээл, энэ нь журмын дагуу хэрхэн ангилагдах эсэх,
- 1.16 Орон нутаг дахь зээлийн давхардлыг шалгаж, эрсдэлийн түвшинд үнэлгээ өгөх,
- 1.17 Активын эрсдэлийн сан байгуулсан байдал, түүний зарцуулалтыг шалгах, активт эрсдэлийн сан байгуулж байгаа бодлого, түүний хэрэгжилт,
- 1.18 Банкнаас аливаа этгээд, түүнтэй холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь Банкны тухай хуульд заасан шаардлагыг хангах эсэх,
- 1.19 Банкны холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын дээд хэмжээ нь Банкны тухай хуульд заасан нэг зээлдэгчид олгох зээлийн хязгаарлалт болон дээрх зээлийг олгохдоо Банкны тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх,
- 1.20 Хоорондоо холбоотой этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь Банкны тухай хуульд заасан хязгаарлалтыг хангаж буй эсэх,
- 1.21 Зээлийн мэдээллийн санд ирүүлж байгаа мэдээ үнэн зөв, шаардлагыг хангаж байгаа эсэхийг Зээлийн мэдээллийн санд ирүүлсэн тайлан мэдээтэй тулгаж шалгах,
- 1.22 Зээлийн төвлөрлийн хэмжээ буюу том зээлийн өрийн үлдэгдэл, өөрийн хөрөнгийн харьцааг системийн дундажтай харьцуулах,
- 1.23 Нийт активт эзлэх чанаргүй зээлийн хувь, хэмжээ, нийт активт эзлэх чанаргүй зээлийн өөрчлөлт, нийт активт орлого авчирдаггүй активын эзлэх хувь хэмжээг бүлгийн дундажтай харьцуулах,
- 1.24 Нийт цэвэршүүлсэн активт өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эзлэх хувь хэмжээ тооцох,
- 1.25 Эрсдэлтэй активыг зохих журмын дагуу ангилж, тайлан тэнцэлд тухай бүр тусгасан эсэхийг тогтоох,

- 1.26 Авлагын дансны үлдэгдлийг нэрийн данс болон шалгалт хамарсан хугацааны туршид гарсан гүйлгээг түүвэрчлэн шалгаж, авлага үүссэн байдлыг тогтоон, шалгалт хийсэн өдрийн үлдэгдлийг өмнөх шалгалтын үеийн байдалтай харьцуулан дүгнэлт өгөх,
- 1.27 Бусад актив хөрөнгийн задаргааг холбогдох баримтаар шалгах,
- 1.28 Иргэд, байгууллагад урьдчилгаагаар олгосон тооцоог цаг хугацаанд нь хийж байгаа эсэх,
- 1.29 Зээлийн хүүг хугацаанд нь хуримтлуулж тооцож байгаа эсэх, хугацаа хэтэрсэн хүүг холбогдох журмын дагуу балансын гадуур бүртгэж байгаа эсэх,
- 1.30 Авлагын эрсдэлийн санг журмын дагуу байгуулж байгаа эсэх,
- 1.31 Үндсэн ба биет бус хөрөнгийн бүтэц, түүний бүртгэл,
- 1.32 Үндсэн хөрөнгийн дүн “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын үндсэн хөрөнгийн үзүүлэлтийг хангаж байгаа эсэх,
- 1.33 Үндсэн хөрөнгө, эд хогшил, материалын дансад хагас, бүтэн жилээр хийсэн тооллогын жагсаалт, танилцуулга, хөрөнгийг шилжүүлсэн, устгасан, худалдсан зэрэгтэй холбогдсон үйл ажиллагаа хууль, тогтоомжтой нийцэж байгаа эсэх,
- 1.34 Дутагдал, илүүдэл, шамшигдал гарч байсан байдал, түүнийг хэрхэн бүртгэж, барагдуулж байсан эсэх,
- 1.35 Активын эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн түвшинг тогтоох,
- 1.36 Дотоод хяналтын газраас банкны активын чанарыг шалгасан байдал, өгсөн үнэлгээ, авсан арга хэмжээ, үр дүн,
- 1.37 Урт хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц, өөрчлөлт,
- 1.38 Эх үүсвэргүй аккредитив, баталгаа, батлан даалтын данс нээсэн эсэх, данс бүртгэлд тусгасан эсэх, тэдгээрийн чанар,
- 1.39 Банк хоорондын тооцоог жил, улирлын байдлаар нийлж тохируулсан байдлыг шалгах,

Гадаад төлбөр тооцоо

- 1.40 Гадаадын банкинд нээсэн нийт хадгаламж, харилцахын ... хувийг шалгах,
- 1.41 Банкны свифтийн сүлжээнд нэвтрэн орж холбогдох мэдээллийг баталгаажуулах,
- 1.42 Гадаад валют худалдан авах, худалдах үйл ажиллагаа, түүний бүртгэлийг Банкны нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу хөтөлж буй эсэх,
- 1.43 Тэнцлийн гадуур бүртгэлтэй гадаад валютын арилжаагаар хүлээсэн үүргүүдийг банкны данс бүртгэл, тайлан тэнцэлд бүрэн тусгасан эсэх,
- 1.44 Гадаад валютын эрсдэлийн тайланг Монголбанкинд тогтоосон хугацаанд ирүүлсэн эсэх, тэр нь үнэн зөв байсан эсэхийг шалган тогтоох,
- 1.45 Дотоод хяналтын газраас гадаад төлбөр тооцооны үйл ажиллагааг шалгасан байдал, гарсан зөрчил, авсан арга хэмжээ, үр дүн.
- 1.46 Гадаад төлбөр тооцооны үйл ажиллагааны эрсдэлийн түвшинд үнэлгээ өгч, хандлагыг тодорхойлох.

Хоёр. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

- 2.1 Өөрийн хөрөнгө, нийт активын зохистой харьцаа, түүний дотор нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцааг хангаж ажиллаж буй эсэх,
- 2.2 Өөрийн хөрөнгийн өсөлт болон активын өсөлтийг харьцуулсан дүгнэлт өгөх, активын чанар ашигт ажиллагааг дэмжиж, өөрийн хөрөнгийн өсөлтөд үзүүлж байгаа нөлөөлөл,
- 2.3 Дүрмийн сангийн бүтэц, дүрмийн сангийн өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн дансдаар нэг бүрчлэн шалгах,

- 2.4 Дүрмийн сангийн өөрчлөлт нь “Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ын хүрээнд хийгдсэн эсэх талаар үндсэн баримтаар баталгаажуулах,
- 2.5 Өөрийн хөрөнгөд эрсдэлийн үзүүлэх нөлөөлөл,
- 2.6 Нөөцийн болон дахин үнэлгээний зэрэг бусад сангийн бүрдэл, түүний зарцуулалт,
- 2.7 Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэлийн түвшинд үнэлгээ өгч, хандлагыг тодорхойлох,
- 2.8 Нэг болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцааг тодорхойлох, өөрийн хөрөнгийн харьцааг тооцохдоо холбогдох тохируулгыг хийж буй эсэх талаар шалгаж тогтоох,
- 2.9 Хоёрдогч өглөгтэй холбоотой гэрээ хэлцлийг үзэж, дүгнэлт өгөх,
- 2.10 Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг бүлгийн дундаж үзүүлэлттэй харьцуулж, дүгнэлт өгөх,
- 2.11 Банк, түүний охин болон хараат компани нь санхүүгийн тайлангаа Банкны тухай хууль, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан шаардлагын дагуу гаргаж байгаа эсэхэд үнэлэлт өгөх,

Гурав. Ашигт ажиллагаа

- 3.1 Өнгөрсөн оны жилийн эцсийн орлого, зарлага, ашиг тооцсон байдал, санхүүгийн жилийн хаалтын гүйлгээг хийсэн байдал,
- 3.2 Аудитын хуулийн дагуу хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, шалгаруулсан эсэх,
- 3.3 Хөндлөнгийн хяналтын байгууллагаас жилийн эцсийн ашигт ажиллагаанд өгсөн дүгнэлт, өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг хөндлөнгийн хяналтын байгууллагаар баталгаажуулан олон нийтэд мэдээлсэн байдал,
- 3.4 Шалгах өдрийн байдлаар орлого, зарлагын байдлыг өссөн дүнгээр гаргаж, ашиг алдагдлыг тооцож, дүгнэлт өгөх,
- 3.5 Гүйлгээний орлого, зарлагын бүтэц,
- 3.6 Ханшийн тэгшитгэл хийсэн байдал, түүнээс бий болсон орлого, зарлагын байдал,
- 3.7 Орлогын гол эх үүсвэр, хүүгийн орлого төсөвлөсөн хэмжээнд хүрсэн эсэх,
- 3.8 Орлого, зарлага, ашигт ажиллагааны байдлыг шалгалт хамрах хугацааны баримтаар түүвэрчлэн шалган тогтоож, үнэлэлт дүгнэлт өгөх,
- 3.9 Активын эрсдэлийн санг бүрэн байгуулсан эсэх, тэдгээрийн зардал ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг судалж, дүгнэлт өгөх,
- 3.10 Онцгой шинжтэй орлого, зардлыг зүйл тус бүрээр нь шалгах,
- 3.11 Дотоод хяналтын газраас банкны орлого, зарлагын байдалд хяналт тавьсан байдал, авсан арга хэмжээ, үр дүн,
- 3.12 Ашигт ажиллагааны эрсдэлийн түвшинд үнэлгээ өгч, хандлагыг тодорхойлох,
- 3.13 Нийт активын өгөөжийн жилийн дундаж үзүүлэлт, өөрийн хөрөнгийн өгөөжийн сарын дундаж үзүүлэлт, цэвэр хүүгийн зөрүүгийн харьцааг бүлгийн дундаж үзүүлэлттэй харьцуулж, дүгнэлт өгөх.

Дөрөв. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

- 4.1 Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн бүтэц, тэдгээрийн хугацааны эрсдэлийг тооцон, дүгнэлт өгөх,
- 4.2 Аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн харилцах дансдын үлдэгдэл, түүний татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь хэмжээг тогтоох,
- 4.3 Заавал байлгах нөөцийг хангасан байдал,

- 4.4 Банк бус байгууллагаас татсан эх үүсвэр, түүнийг өмнөх шалгалтын үеийн байдалтай харьцуулж, дүгнэлт өгөх,
- 4.5 Бусад банкнаас татсан эх үүсвэр, түүнийг өмнөх шалгалтын үеийн байдалтай харьцуулж, дүгнэлт өгөх,
- 4.6 Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийг зөв тооцож байгаа эсэхийг тооцож, дүгнэлт өгөх,
- 4.7 Нийгмийн хөгжлийн сан, түүний зарцуулалт,
- 4.8 Харилцагчдын төлбөр тооцоог саатуулж байгаа эсэх,
- 4.9 Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх талаар банкнаас банкны явуулж байгаа бодлого, хүлээж болзошгүй үүргийг барагдуулах төлөвлөгөө байгаа эсэх,
- 4.10 Дотоод хяналтын газраас банкны төлбөрийн чадварыг дүгнэсэн байдал, хийсэн судалгаа, үр дүн,
- 4.11 Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн түвшинд үнэлгээ өгч, хандлагыг тодорхойлох,
- 4.12 Банк өөрийн санхүүгийн чадавхийг хамгаалах, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд давж гарах зорилгыг тусгасан хөрвөх чадварын удирдлагын талаар баримтлах стратегитэй эсэх, стратегийн бодлого, зарчмуудын тухай,
- 4.13 Хөрвөх чадварын удирдлагын талаар баримтлах стратегийн талаарх банкны дотоод дүрэм, журамтай эсэх,
- 4.14 Банк хөрвөх чадварын түвшинг найдвартай хэмжих, хянах, удирдах, тайлагнах зорилгоор мэдээллийн системийг бүрдүүлсэн эсэх,
- 4.15 Банк онцгой нөхцөл байдал үүссэн үед хэрэгжүүлэх “Хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-тэй эсэх,
- 4.16 Банк нь орох гарах мөнгөн урсгалын тайланг ямар хугацаанд тооцдог болох,
- 4.17 Үндсэн хөрөнгө, эд хогшлын элэгдэл хорогдлын тооцоог зохих хугацаанд нь бодож бодож, холбогдох дансанд бүртгэсэн байдал,
- 4.18 Иргэд, байгууллагатай хийх тооцоогоор үүссэн өглөгийг цаг хугацаанд нь хийж байсан эсэх,
- 4.19 Байгууллага, иргэдийн хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг хэрхэн тогтоосон байдал, хадгаламжийн хүү бодолтыг хэсэгчлэн шалгаж, хүүг хугацаанд нь данс бүртгэлд үнэн зөв тусгасан эсэх,
- 4.20 Байгууллага, иргэдийн хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг хэрхэн тогтоосон байдал, хадгаламжийн хүү бодолтыг хэсэгчлэн шалгаж, хүүг хугацаанд нь данс бүртгэлд үнэн зөв тусгасан эсэх.
- 4.21 Актив, пассивын хүүгийн болон хугацааны зөрүүгийн шинжилгээ хийх, дүгнэлт өгөх.

Тав. Эрсдэлийн мэдрэмж

- 5.1 Банкны үйл ажиллагаанд үүсч буй зах зээлийн эрсдэл буюу хүүгийн, ханшийн болон үнийн эрсдэлийг хэрхэн хянаж байгаад нэгдсэн дүгнэлт өгөх,
- 5.2 Банкны удирдлага нь зах зээлийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах болон бууруулах, энэхүү эрсдэлээс хамгаалах талаар арга хэмжээ авах замаар эрсдэлийн талаар нэгдсэн үр дүнтэй бодлого явуулдаг эсэх,
- 5.3 Удирдлагын мэдээллийн систем, түүний бүтэц, зохион байгуулалт, үр өгөөж, үүнд үндэслэн шийдвэр гарч байгаа эсэхийг шалгах.
- 5.4 Эрсдэлийн эх сурвалж болон уялдаа холбоог судалж, зах зээлийн хүү, үнийн өөрчлөлт, ханшийн хэлбэлзэлтэй уялдуулан банкны цаашдын бодлого, үйл ажиллагааг удирдан явуулж байгаа эсэх,
- 5.5 Эрсдэл хүлээж буй нөхцөлд банкны удирдлага эрсдэлийг даван гарах арга, бололцоо, учирсан хохирлыг нөхөх, арилгах чадвартай эсэхээ хэрхэн тооцож үнэлдэг,

- 5.6 Банк нь эрсдэлээ хэрхэн үнэлдэг, эрсдэлийг үнэлэх арга нь боловсронгуй эсэх, банкны үйл ажиллагааны цар хүрээнд тохирсон эсэх,
- 5.7 Банкны дотоод хяналтын газрын үйл ажиллагаа нь банкны учирч буй эрсдэлүүдийг илрүүлэх, бууруулахад чиглэсэн эсэх, энэ талаар авсан арга хэмжээ, үр дүн.
- 5.8 Хүүгийн эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн түвшинг тогтоох,
- 5.9 Банкны үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг тогтоох, хандлагыг тодорхойлох,
- 5.10 Гадаад валютын эрсдэлийг Хамгийн их эрсдэлийн аргаар тооцох зөвшөөрөл авсан банкны уг тооцооллын арга нь банкны эрсдэлийг хир бодитой тооцоолж байгааг үнэлэх.

Зургаа. Зохистой удирдлагын үйл ажиллагаа

- 6.1 Банкны бүтэц, удирдлага, зохион байгуулалт,
- 6.2 Банкны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй заавар журам, бусад эрхийн акт, тэдгээрийг холбогдох журмын дагуу Монголбанкинд бүртгүүлсэн эсэх,
- 6.3 Банкны үйл ажиллагааны талаар бизнес төлөвлөгөөг боловсруулсан байдал, түүний хэрэгжилт,
- 6.4 Монголбанкнаас баталсан зохистой удирдлагын зарчмын хэрэгжилтийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх,
- 6.5 Актив, пассивын удирдлага, Зээлийн хорооны үйл ажиллагаа,
- 6.6 Дотоод хяналтын албаны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, үр дүн,
- 6.7 Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх захирал нь хуульд заасан шаардлагуудыг ханган ажиллаж байгаа эсэхийг тогтоох, энэ талаар холбогдох баримтаа Монголбанкинд ирүүлсэн эсэхийг шалгах.
- 6.8 Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлөөс банкны үйл ажиллагаанд тавьж буй хяналт, түүний үр дүн.
- 6.9 Банк шаардлагатай мэдээллийг ил тод болгосон эсэх.
- 6.10 Банкны хувь нийлүүлэгчдийн бүтэц, үүрэг дэлгэрэнгүй байгаа эсэх.
- 6.11 Гадаад аудитын байгууллагын эрх үүрэг тодорхой тусгагдсан эсэх,
- 6.12 Банкны аудитын хороо болон дотоод аудитын эрх, үүрэг тодорхой тусгагдсан байгаа эсэх,

Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлага

- 6.13 Банк нь өөрийн мэдээллийн системийн эрсдэлийн удирдлага, системийн аудитын хүрээнд системийн мөчлөгийн холбогдох үе шат бүрт хамаарах, мэдээллийн системийн төлөвлөлт ба удирдлага,
- 6.14 Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан эсэх,
- 6.15 Мэдээллийн технологийн систем боловсруулалт, системийн үйл ажиллагаа, ашиглалт
- 6.16 Системд оруулж буй болон системээс гарч буй мэдээлэл, сүлжээний найдвартай аюулгүй байдлыг хангасан байдал
- 6.17 Мэдээллийн системийн нөөцийн удирдлага
- 6.18 Программ хангамжийн найдвартай байдлыг хангах талаар гүйцэтгэгч байгууллагуудтай хийгдсэн гэрээ хэлцэл, түүний хэрэгжилт
- 6.19 Мэдээллийн системийн нөөц төлөвлөгөө болон баримтжуулалт
- 6.20 Мэдээллийн технологийн эрсдэлийг удирдах дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны стандартыг хэрхэн бүрдүүлж мөрдлөг болгон ажиллаж байгаад үнэлгээ дүгнэлт өгөх,

Долоо. Банкны нэгжийн үйл ажиллагаа

- 7.1 Харьяа салбар, тооцооны төв, кассын үйл ажиллагаа /тухайн банкны нэгж бүхий аймгуудын Монголбанкны салбарт шалгалт хийх тухай мэдэгдэнэ./, тэдгээр нь зохих журмын дагуу Монголбанкинд бүртгүүлж, зөвшөөрөл авсан эсэх,
- 7.2 Шаардлагатай тохиолдолд тус банкны салбар нэгжид газар дээр нь шалгалт хийнэ.

Найм. Бусад зүйл

- 8.1 Банкны удирдлага, банктай холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь Монголбанкны хянан шалгагчийн зүгээс нэмж тодруулах шаардлагатай удирдамжид тусгагдаагүй санхүүгийн тайлан, санхүүгийн анхан шатны баримт, тэдгээрийг нотлох баримт, хууль тогтоомжийн дагуу банкны удирдлагын үйл ажиллагааны талаар бүрдүүлбэл зохих баримт, мэдээ, мэдээлэл болон санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа тоног төхөөрөмж, түүний программ, дэд программ хангамж, тэдгээрийн байршлын талаархи дэлгэрэнгүй жагсаалт, тэдгээрт нэвтрэх нууц түлхүүрийг Монголбанкны хянан шалгагчид саадгүй, бүрэн гүйцэд, үнэн зөв гарган өгч, хяналт шалгалтын үйл ажиллагааг бие даасан, хараат бусаар явуулах нөхцөлөөр хангана.
- 8.2 Тайлан тэнцэл үнэн бодитой гарсан талаар банкны удирдлагаас баталгаа бичиг гаргуулан авч болно.
- 8.3 Шалгалтын акт материалыг баталгаажуулах зорилгоор шаардлагатай касс, мемориалын баримтыг шалгаж болно.

III. Шалгалтын дүнг гаргах

1. Шалгалтын явцад ажлын хэсгийн улсын байцаагч нар улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж, төлбөр, зөрчил, дутагдал нэг бүрт акт тогтоон засч, залруулах гүйлгээг газар дээр нь хийлгүүлэн, шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

2. Тухайн банкны үйл ажиллагаа санхүү, төлбөрийн чадварын байдалд "Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журам"-ын дагуу үнэлэлт дүгнэлт өгнө.

3. Ажлын хэсэг удирдамжийн дагуу шалгалт хийсэн тухай акт материалыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 23 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу бичиж, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний талаар саналаа шалгалт хийж дууссанаас хойш ажлын ... өдрийн дотор боловсруулж Монголбанкны удирдлагад танилцуулахад бэлэн болгоно.

4. Ажлын хэсгийн ахлагч шалгалтын акт материалыг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, түүний мөрөөр шийдвэр гаргуулан, биелэлтэнд Хяналт шалгалтын газрын Зайнаас хяналт тавих хэлтсийн банк хариуцсан хянан шалгагч хяналт тавьж ажиллана.

Монголбанкны Хяналт шалгалтын
газраас банкуудад явуулах газар
дээрх шалгалтын нийтлэг
удирдамжийн хавсралт

УДИРДАМЖИЙН АСУУЛГЫН ХҮСНЭГТ

Нэг. Активын чанар

Д/д	Асуулт	(Тийм/Үгүй)	Тайлбар
1.1	Касс үнэ бүхий зүйлийн хадгалалт, хамгаалалтын шаардлага хангаж байгаа эсэх,		
1.2	Кассын үйл ажиллагааны талаар гарсан заавар, журмын хэрэгжилт хангалттай эсэх,		
1.3	Монголбанкинд бэлэн мөнгө тушаасан байдал, түүнээс зөрчил, дутагдал гарч байсан эсэх,		
1.4	Банк хооронд байршуулсан хадгаламж, харилцах дансны үлдэгдлийн үндсэн баримт, холбогдох гэрээнүүд хууль, журамд нийцэж байгаа эсэх,		
1.5	Банкны худалдан авсан болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны дүн нь Банкны тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх,		
1.6	Зээлийн бодлого, түүний хэрэгжилт, зээл олгох эрх хэмжээ зүй зохистой байгаа эсэх,		
1.7	Анхны нөхцөл өөрчлөгдсөн зээл, энэ нь журмын дагуу хэрхэн ангилагдах эсэх,		
1.8	Активын эрсдэлийн сан байгуулсан байдал, түүний зарцуулалтыг шалгах, активт эрсдэлийн сан байгуулж байгаа бодлого, түүний хэрэгжилт хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх,		
1.9	Банкнаас аливаа этгээд, түүнтэй холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь Банкны тухай хуульд заасан шаардлагыг хангах эсэх,		
1.10	Банкны холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын дээд хэмжээ нь Банкны тухай хуульд заасан нэг зээлдэгчид олгох зээлийн хязгаарлалт болон дээрх зээлийг олгохдоо Банкны тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх,		
1.11	Хоорондоо холбоотой этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь Банкны тухай хуульд заасан хязгаарлалтыг хангаж буй эсэх,		
1.12	Зээлийн мэдээллийн санд ирүүлж байгаа мэдээ үнэн зөв, шаардлагыг хангаж байгаа эсэхийг Зээлийн мэдээллийн санд ирүүлсэн тайлан мэдээтэй тохирч байгаа эсэх,		
1.13	Эрсдэлтэй активыг зохих журмын дагуу ангилж, тайлан тэнцэлд тухай бүр тусгасан эсэх,		
1.14	Иргэд, байгууллагад урьдчилгаагаар олгосон тооцоог		

	цаг хугацаанд нь хийж байгаа эсэх,		
1.15	Зээлийн хүүг хугацаанд нь хуримтлуулж тооцож байгаа эсэх, хугацаа хэтэрсэн хүүг холбогдох журмын дагуу балансын гадуур бүртгэж байгаа эсэх,		
1.16	Авлагын эрсдэлийн санг журмын дагуу байгуулж байгаа эсэх,		
1.17	Үндсэн ба биет бус хөрөнгийн бүтэц, түүний бүртгэл заавар, журмын дагуу байгаа эсэх,		
1.18	Үндсэн хөрөнгийн дүн “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын үндсэн хөрөнгийн үзүүлэлтийг хангаж байгаа эсэх,		
1.19	Үндсэн хөрөнгө, эд хогшил, материалын дансад хагас, бүтэн жилээр хийсэн тооллогын жагсаалт, танилцуулга, хөрөнгийг шилжүүлсэн, устгасан, худалдсан зэрэгтэй холбогдсон үйл ажиллагаа хууль, тогтоомжтой нийцэж байгаа эсэх,		
1.20	Дутагдал, илүүдэл, шамшигдал гарч байсан байдал, түүнийг хэрхэн бүртгэж, барагдуулж байсан эсэх,		
1.21	Эх үүсвэргүй аккредитив, баталгаа, батлан даалтын данс нээсэн эсэх, данс бүртгэлд тусгасан эсэх,		

Гадаад төлбөр тооцоо

Д/д	Асуулт	Тийм/Үгүй	Тайлбар
1.36	Банкны свифтийн сүлжээнд нэвтрэн орж холбогдох мэдээллийг баталгаажуулж чадсан эсэх,		
1.37	Гадаад валют худалдан авах, худалдах үйл ажиллагаа, түүний бүртгэлийг Банкны нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу хөтөлж буй эсэх,		
1.38	Тэнцлийн гадуур бүртгэлтэй гадаад валютын арилжаагаар хүлээсэн үүргүүдийг банкны данс бүртгэл, тайлан тэнцэлд бүрэн тусгасан эсэх,		
1.39	Гадаад валютын эрсдэлийн тайланг Монголбанкинд тогтоосон хугацаандаа, үнэн зөв ирсэн эсэх,		
1.40	Дотоод хяналтын газраас гадаад төлбөр тооцооны үйл ажиллагааг шалгасан эсэх, гарсан зөрчилд авсан арга хэмжээ нь зохистой эсэх, үр дүнд хүрсэн эсэх,		

Хоёр. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Д/д	Асуулт	Тийм/Үгүй	Тайлбар
2.12	Өөрийн хөрөнгө, нийт активын зохистой харьцаа, түүний дотор нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцааг хангаж ажиллаж буй эсэх,		
2.13	Дүрмийн сангийн бүтэц, дүрмийн сангийн өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн дансдаар нэг бүрчлэн шалгахад зөрчил гарсан эсэх,		
2.14	Дүрмийн сангийн өөрчлөлт нь “Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ын хүрээнд хийгдсэн эсэх,		

2.15	Нөөцийн болон дахин үнэлгээний зэрэг бусад сангийн бүрдэл, түүний зарцуулалт, хууль, журамд нийцэж байгаа эсэх,		
2.16	Нэг болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцааг тодорхойлох, өөрийн хөрөнгийн харьцааг тооцохдоо холбогдох тохируулгыг хийж буй эсэх,		
2.17	Хоёрдогч өглөгтэй холбоотой гэрээ хэлцэл хууль, журамд нийцэж байгаа эсэх,		
2.18	Банк, түүний охин болон хараат компани нь санхүүгийн тайлангаа Банкны тухай хууль, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан шаардлагын дагуу гаргаж байгаа эсэх,		

Гурав. Ашигт ажиллагаа

Д/д	Асуулт	Тийм/Үгүй	Тайлбар
3.1	Өнгөрсөн оны жилийн эцсийн орлого, зарлага, ашиг тооцсон байдал, санхүүгийн жилийн хаалтын гүйлгээг журмын дагуу хийсэн эсэх,		
3.2	Аудитын хуулийн дагуу хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, шалгаруулсан эсэх,		
3.3	Хөндлөнгийн хяналтын байгууллагаас жилийн эцсийн ашигт ажиллагаанд өгсөн дүгнэлт, өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг хөндлөнгийн хяналтын байгууллагаар баталгаажуулан олон нийтэд мэдээлсэн эсэх,		
3.4	Орлогын гол эх үүсвэр, хүүгийн орлого төсөвлөсөн хэмжээнд хүрсэн эсэх,		
3.5	Активын эрсдэлийн санг бүрэн байгуулсан эсэх,		
3.6	Онцгой шинжтэй орлого, зардлыг зүйл тус бүрээр нь шалгахад зөрчил гарсан эсэх,		
3.7	Дотоод хяналтын газраас банкны орлого, зарлагын байдалд хяналт тавьсан байдал зохистой эсэх, авсан арга хэмжээ нь үр дүнтэй эсэх,		

Дөрөв. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

Д/д	Асуулт	Тийм/Үгүй	Тайлбар
4.1	Заавал байлгах нөөцийг хангасан эсэх,		
4.2	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийг зөв тооцож байгаа эсэх,		
4.3	Нийгмийн хөгжлийн сан, түүний зарцуулалт хууль, журамд нийцэж байгаа эсэх,		
4.4	Харилцагчдын төлбөр тооцоог саатуулж байгаа эсэх,		
4.5	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх талаар банкнаас банкны явуулж байгаа бодлого, хүлээж болзошгүй үүргийг барагдуулах төлөвлөгөө байгаа эсэх,		
4.6	Дотоод хяналтын газраас банкны төлбөрийн чадварыг дүгнэсэн эсэх, авсан арга хэмжээ нь зохистой эсэх		

4.7	Банк өөрийн санхүүгийн чадавхийг хамгаалах, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд давж гарах зорилгыг тусгасан хөрвөх чадварын удирдлагын талаар баримтлах стратегитэй эсэх,		
4.8	Хөрвөх чадварын удирдлагын талаар баримтлах стратегийн талаарх банкны дотоод дүрэм, журамтай эсэх,		
4.9	Банк хөрвөх чадварын түвшинг найдвартай хэмжих, хянах, удирдах, тайлагнах зорилгоор мэдээллийн системийг бүрдүүлсэн эсэх,		
4.10	Банк онцгой нөхцөл байдал үүссэн үед хэрэгжүүлэх “Хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-тэй эсэх,		
4.11	Банк нь орох гарах мөнгөн урсгалын тайланг ямар хугацаанд тооцдог нь журамд нийцэж байгаа эсэх,		
4.12	Үндсэн хөрөнгө, эд хогшлын элэгдэл хорогдлын тооцоог зохих хугацаанд нь бодож бодож, холбогдох дансанд бүртгэж байгаа эсэх,		
4.13	Иргэд, байгууллагатай хийх тооцоогоор үүссэн өглөгийг цаг хугацаанд нь хийж байсан эсэх,		
4.14	Байгууллага, иргэдийн хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг хэрхэн тогтоосон байдал, хадгаламжийн хүү бодолтыг хэсэгчлэн шалгаж, хүүг хугацаанд нь данс бүртгэлд үнэн зөв тусгасан эсэх,		
4.15	Байгууллага, иргэдийн хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг хэрхэн тогтоосон байдал, хадгаламжийн хүү бодолтыг хэсэгчлэн шалгаж, хүүг хугацаанд нь данс бүртгэлд үнэн зөв тусгасан эсэх.		

Тав. Эрсдэлийн мэдрэмж

Д/д	Асуулт	Тийм/Үгүй	Тайлбар
5.1	Банкны удирдлага нь зах зээлийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах болон бууруулах, энэхүү эрсдэлээс хамгаалах талаар арга хэмжээ авч, эрсдэлийн талаар нэгдсэн үр дүнтэй бодлого явуулдаг эсэх,		
5.2	Удирдлагын мэдээллийн систем, түүний бүтэц, зохион байгуулалт, үр өгөөж, үүнд үндэслэн шийдвэр гарч байгаа эсэх,		
5.3	Эрсдэлийн эх сурвалж болон уялдаа холбоог судалж, зах зээлийн хүү, үнийн өөрчлөлт, ханшийн хэлбэлзэлтэй уялдуулан банкны цаашдын бодлого, үйл ажиллагааг удирдан явуулж байгаа эсэх,		
5.4	Эрсдэл хүлээж буй нөхцөлд банкны удирдлага эрсдэлийг даван гарах арга, бололцоо, учирсан хохирлыг нөхөх, арилгах чадвартай эсэхээ тооцож үнэлдэг эсэх,		
5.5	Банк нь эрсдэлээ хэрхэн үнэлдэг, эрсдэлийг үнэлэх		

	арга нь боловсронгуй эсэх, банкны үйл ажиллагааны цар хүрээнд тохирсон эсэх,		
5.6	Банкны дотоод хяналтын газрын үйл ажиллагаа нь банкны учирч буй эрсдэлүүдийг илрүүлэх, бууруулахад чиглэсэн эсэх, авсан арга хэмжээ нь зохистой эсэх,		
5.7	Хүүгийн эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн түвшинг тогтоох,		
5.8	Гадаад валютын эрсдэлийг Хамгийн их эрсдэлийн аргаар тооцох зөвшөөрөл авсан банкны уг тооцооллын арга нь банкны эрсдэлийг бодитой тооцоолж байгаа эсэх.		

Зургаа. Зохистой удирдлагын үйл ажиллагаа

Д/д	Асуулт	Тийм/Үгүй	Тайлбар
6.21	Банкны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй заавар журам, бусад эрхийн акт, тэдгээрийг холбогдох журмын дагуу Монголбанкинд бүртгүүлсэн эсэх,		
6.22	Монголбанкнаас баталсан зохистой удирдлагын зарчмын хэрэгжилтийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх,		
6.23	Актив, пассивын удирдлага, Зээлийн хорооны үйл ажиллагаа нь зохистой эсэх,		
6.24	Дотоод хяналтын албаны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, үр дүн,		
6.25	Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх захирал нь хуульд заасан шаардлагуудыг ханган ажиллаж байгаа эсэх,		
6.26	Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлөөс банкны үйл ажиллагаанд тавьж буй хяналт үр дүнтэй эсэх,		
6.27	Банк шаардлагатай мэдээллийг ил тод болгосон эсэх,		
6.28	Банкны хувь нийлүүлэгчдийн бүтэц, үүрэг дэлгэрэнгүй байгаа эсэх.		
6.29	Гадаад аудитын байгууллагын эрх үүрэг тодорхой тусгагдсан эсэх,		
6.30	Банкны аудитын хороо болон дотоод аудитын эрх, үүрэг тодорхой тусгагдсан байгаа эсэх,		

Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлага

Д/д	Асуулт	Тийм/Үгүй	Тайлбар
6.12	Банкны аудитын хороо болон дотоод аудитын эрх, үүрэг тодорхой тусгагдсан байгаа эсэх,		
6.13	Банк нь өөрийн мэдээллийн системийн эрсдэлийн удирдлага, системийн аудитын хүрээнд системийн мөчлөгийн холбогдох үе шат бүрт хамаарах, мэдээллийн системийн төлөвлөлт ба удирдлагатай эсэх,		
6.14	Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан эсэх,		
6.15	Мэдээллийн технологийн систем боловсруулалт, системийн үйл ажиллагаа, ашиглалт зохистой эсэх,		

6.16	Системд оруулж буй болон системээс гарч буй мэдээлэл, сүлжээний найдвартай аюулгүй байдлыг хангасан байдал нь зохистой эсэх,		
6.17	Мэдээллийн системийн нөөц төлөвлөгөө болон баримтжуулалт зохистой эсэх,		
6.18	Мэдээллийн технологийн эрсдэлийг удирдах дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны стандартыг хэрхэн бүрдүүлж мөрдлөг болгон ажиллаж байгаа эсэх.		

Долоо. Банкны нэгжийн үйл ажиллагаа

Д/д	Асуулт	Тийм/Үгүй	Тайлбар*
7.3	Харьяа салбар, тооцооны төв, кассын үйл ажиллагаа /тухайн банкны нэгж бүхий аймгуудын Монголбанкны салбарт шалгалт хийх тухай мэдэгдэнэ./, тэдгээр нь зохих журмын дагуу Монголбанкинд бүртгүүлж, зөвшөөрөл авсан эсэх,		

Тайлбар: Тайлбар* хэсэгт холбогдох тайлбарыг бичнэ.

--- о О о ---